



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ
**МЕХАНИК ИНЖЕНЕР, ТЭЭВРИЙН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2025 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 8/34

Улаанбаатар хот

Шинээр байгуулагдсан тэнхимийн
эрхлэгчийн сонгон шалгаруулалтын
удирдамж батлах тухай

ШУТИС-ийн дурмийн 5.11 дэх заалт, ШУТИС-ийн Ректорын 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн "Шинээр байгуулагдсан тэнхимийн эрхлэгчийн сонгон шалгаруулалт явуулах тухай" А/160 тоот тушаалыг үндэслэн ТУШААХ НЬ:

- ШУТИС-ийн "Механик инженер, тээврийн сургуулийн тэнхимийн эрхлэгчийн сонгон шалгаруулах удирдамж"-ийг хавсралтаар баталсугай.
- Батлагдсан удирдамжийн дагуу сонгон шалгаруулалтыг зохион байгуулахыг "Механик инженер, тээврийн сургуулийн тэнхимийн эрхлэгч нарыг сонгон шалгаруулах комисс"-т үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ

Н.ПҮРЭВДОРЖ



367740111

МИТС-ийн захирлын 2025 оны
15.-р сарын 19.-ны өдрийн
тоот тушаалын хавсралт

Механик инженер, тээврийн сургуулийн тэнхимийн эрхлэгчийн
сонгон шалгаруулах удирдамж



Нэг. Нийтлэг үндэслэл

ШУТИС-ийн Механик инженер, тээврийн сургуулийн Машин үйлдвэрлэлийн тэнхимийн эрхлэгч; Механик инженерчлэлийн тэнхимийн эрхлэгч; Механик, мехатроникийн тэнхимийн эрхлэгч; Тээвэр, логистикийн тэнхимийн эрхлэгчийг тус тус сонгон шалгаруулахтай холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү удирдамжийг баримтална.

- 1.1. Тэнхимийн эрхлэгчийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулахдаа хүний эрх, нэр төр, мэргэжлийн нэр хүндийг хүндэтгэх, үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал үүслээр нь ялгavarлан гадуурхахгүй байх, тэгш хандах, хууль тогтоомж, шударга ёсыг дээдлэх, нууцыг хадгалах, нээлттэй ил тод, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зарчмыг баримтална.
- 1.2. ШУТИС-ийн Ректорын тушаалаар батлагдсан “Механик инженер, тээврийн сургуулийн тэнхимийн эрхлэгч нарыг сонгон шалгаруулах комисс” нь энэхүү удирдамжийн дагуу сонгон шалгаруулалтыг явуулж, тайлан, холбогдох материалыг ШУТИС-ийн Захиргааны удирдлагын газарт хүргүүлнэ.
- 1.3. Сонгон шалгаруулалтын комиссын нэг гишүүнийг нарийн бичгийн даргаар сонгон ажиллуулна.
- 1.4. Механик инженер, тээврийн сургуулийн тэнхимийн эрхлэгч нарыг сонгон шалгаруулах зарыг ШУТИС-ийн болон МИТС-ийн албан ёсны вэб хуудас ашиглан нийтэд хүргэнэ.

Хоёр. Механик инженер, тээврийн сургуулийн тэнхимийн эрхлэгчийн албан тушаалд нэр дэвшигчид тавигдах шаардлага

- 2.1. Дараах шалгуур, шаардлагыг хангасан Монгол Улсын иргэн нь тэнхимийн эрхлэгчийн албан тушаалын сонгон шалгаруулалтанд нэр дэвших эрхтэй. Үүнд:
 - 2.1.1 Доктор (Ph.D)-с доошгүй эрдмийн зэрэгтэй;
 - 2.1.2 Тухайн тэнхимийн сургалт, судалгааны аль нэг чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн;
 - 2.1.3 Их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад 10-аас доошгүй жил ажилласан;
 - 2.1.4 Багшлах болон эрдэм шинжилгээ, судалгааны ажлын дадлага, туршлагатай;
 - 2.1.5 Мэргэжлийн чиглэлээр салбартаа нэр хүндтэй, хариуцсан нэгжийн сургалт, эрдэм шинжилгээний ажил, үйлдвэрлэлийн холбоог хөгжүүлэх чадвартай;
- 2.2. Сонгон шалгаруулалтад оролцогч иргэн зөвхөн нэг тэнхимийн эрхлэгчийн албан тушаалд нэр дэвших эрхтэй.

Гурав. Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтийг хүлээн авах, бүртгэх

- 3.1. Нэр дэвшигч дараах материалыг бүрдүүлнэ. Үүнд:
 - 3.1.1. Сонгон шалгаруулалтад оролцогчийн гараар бичсэн хүсэлт;
 - 3.1.2. Төрийн албан хаагчийн анкет, зурагтай (Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 11 дугээр сарын 14-ний өдрийн 600 дугаар тогтоолоор баталсан анкет),
 - 3.1.3. Иргэний үнэмлэхийн хуулбар эсвэл E-mongolia системээс авсан лавлагаа;
 - 3.1.4. Боловсролын түвшин, эрдмийн зэрэг, цолыг тодорхойлсон баримт бичиг (хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийг баталгаат орчуулгыг хавсаргах)-ийн хуулбар;
 - 3.1.5. Ажлын туршлагын шаардлагыг хангасан тухай нотлох баримт (E-Mongolia лавлагаа, нийгмийн даатгалын дэвтэр, хөдөлмөрийн дэвтэр, албан тушаалд томилогдсон, чөлөөлөгдсөн тушаал шийдвэр г.м)-ийн хуулбар, лавлагаа;
 - 3.1.6. Баталгаажуулсан бүтээлийн жагсаалт;
 - 3.1.7. Тэнхимийг хөгжүүлэх мэрийн хөтөлбөр. Мэрийн хөтөлбөрийг гурван жилээр хэрэгжүүлэхээр төлөвлөн, дараах агуулгаар боловсруулсан байна. Үүнд:
 - 3.1.7.1. ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 13 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан “ШУТИС-2030 стратеги төлөвлөгөө”-ний стратегийн үндсэн зорилт, чиглэлийн хүрээнд тухайн тэнхимд хэрэгжүүлэх үйл ажиллагаа;
 - 3.1.7.2. Тэнхимийн хэрэгжүүлдэг сургалтын хөтөлбөрөөр суралцагчийн тоог нэмэгдүүлэх, сургалтын чанар, материаллаг баазыг дээшлүүлэх, хөтөлбөр хөгжүүлэх зорилгоор хэрэгжүүлэх ажил, тэдгээрийн хүлээгдэж буй үр дүн;
 - 3.1.7.3. Тэнхимийн гадаад харилцаа, хамтын ажиллагаа, нийгмийн түншлэл, мэргэжлийн үйлчилгээ болон оюутны үйлчилгээг хөгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх ажил, тэдгээрийн хүлээгдэж буй үр дүн;
 - 3.1.7.4. Тухайн тэнхимийн хөгжлийг хангахад чиглэсэн өөрийн санаачлан хэрэгжүүлэхээр төлөвлөж буй ажил, төсөл, хөтөлбөр;

Тайлбар. Бүрдүүлэн бичиг баримтыг нотариатаар баталгаажуулсан байхыг шаардахгүй бөгөөд баримт бичгийн үнэн зөвийг хүсэлт гаргасан иргэн өөрөө бүрэн хариуцна.

- 3.2. Сонгон шалгаруулалтад оролцохыг хүссэн иргэн бүрдүүлсэн баримт бичгийг дугтуйнд хийж битүүмжлэн, ШУТИС-ийн хичээлийн 7 дугаар байрны 211 тоот өрөөнд (Механик инженер, тээврийн сургуулийн захирлын туслахд) өөрийн биеэр хүлээлгэн өгнө.

Хүлээн авах хугацаа: 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 09:00 цагаас 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 12:00 цаг хүртэл (Ажлын өдрүүдэд), Холбоо барих утас: 341913 (Ажлын цагаар)

- 3.3. Сонгон шалгаруулалтын комисс нэр дэвшигчдийн ирүүлсэн материалтай танилцаж, нэр дэвшигч тус бүрээр материалын бүрдэл хангасан эсэх, нэр дэвшигч нь тавигдсан шалгуур шаардлагыг хангаж байгаа эсэх, боловсруулсан мөрийн хөтөлбөр нь 3.1.7 заалтанд дурдсан агуулгатай нийцэж байгаа эсэхийг нягтална.
- 3.4. Нэр дэвшигч нь заагдсан шалгуур, шаардлагыг хангаагүй, бичиг баримтын бүрдэл дутуу бол тухайн нэр дэвшигчийг сонгон шалгаруулалтаас хасах үндэслэл болно.

Дөрөв. Нэр дэвшигчийг сонгон шалгаруулах, шийдвэр гаргалт

- 4.1. Сонгон шалгаруулалтын комисс үйл ажиллагааны хуваарийн дагуу нэр дэвшигчдийн холбогдох материалтай танилцана.
- 4.2. Тэнхимиийн эрхлэгчийн албан тушаалд нэр дэвшигчийн бүрдүүлсэн баримт бичиг нь тухайн ажлын байранд тавигдах шаардлага болон бусад тавигдсан нөхцлийг хангасан эсэхийг сонгон шалгаруулалтын комисс нэг бүрчлэн шалгаж, баримтыг дутуу бүрдүүлсэн болон тавигдах шаардлага хангаагүй тохиолдолд сонгон шалгаруулалтаас хасна (нэр дэвшигчийн эзэмшсэн дээд боловсрол нь тухайн тухайн тэнхимиийн сургалт, судалгааны аль нэг чиглэлд нийцэж буй эсэхийг комисс тогтооно).
- 4.3. Материалын бүрдэл нь шаардлага хангасан нэр дэвшигч 2025 оны 05 дугаар сарын 27-29-ны өдрүүдэд гаргасан хуваарийн дагуу мөрийн хөтөлбөрөө тухайн нэр дэвшсэн тэнхимиийн хамт олон болон сонгон шалгаруулалтын комиссын хамтарсан хуралд танилцуулж үнэлүүлнэ.
- 4.4. Хурлын бэлтгэл ажлыг захирлын туслах болон комиссын гишүүд хариуцан зохион байгуулна.
- 4.5. Сонгон шалгаруулалтын комиссын дарга хурлын дэгийг тогтоон, хурлыг удирдана. Хурлын тэмдэглэлийг комиссын нарийн бичгийн дарга хөтлөнө.
- 4.6. Нэр дэвшигчийг тэнхимиийн эрхлэгчээр ажиллуулах эсэхийг хуралд оролцогчдын нууц санал хураалтын дунгээр шийдвэрлэнэ. Тэнхимиийн багш ажилтан болон комиссын гишүүн нь ижил тэгш саналын эрхтэй.
- 4.7. Санал авах маягтыг сонгон шалгаруулалтын комисс боловсруулж баталгаажуулна.
- 4.8. Санал өгөх тэнхимиийн хамт олны ирц нийт багш, ажиллагчдын 80 хувиас дээш үед санал хураалтыг хүчинтэйд тооцно. Гадаадад байгаа болон хүүхэд асрах чөлөөтэй байгаа багш ажилтныг онлайнаар хуралд оролцож санал өгөх эрхтэй.
- 4.9. Тэнхимиийн хамт олны 2 төлөөлөл болон сонгон шалгаруулалтын комиссын нарийн бичгийн дарга нууц санал хураалтыг тоолж, нэр дэвшигч бүрээр гаргана.
- 4.10. Сонгон шалгаруулалтын комисс нэр дэвшигч бүрээр нийт оноог нэгтгэн эрэмбэлж, тэнхимиийн хамт олонд танилцуулна.
- 4.11. Сонгон шалгаруулалтын үйл ажиллагаа дуусахад сонгон шалгаруулалтын комисс нь тайлан, хурлын тэмдэглэл, шалгарсан нэр дэвшигчийн холбогдох материалын, нэр дэвшигчдийн саналын хуудсууд болон бусад баримт бичгийг нэгтгэн 2025.06.02-ны дотор ШУТИС-ийн Захиргааны удирдлагын газарт хүргүүлнэ.